

18-25 насны залуучуудын улс төрчдийг сонгох чиг хандлага

*Фридрих-Эбертийн сангийн 2023-2024
оны тэтгэлэгт оюутнуудын
судалгааны тайлан*

М.Анужин



Б.Есүжин



О.Эрдэмбаяр



Б.Баасансүрэн



Б.Отгонзаяа

Импрессум

Эрхлэн гаргасан

Фридрих-Эбертийн-Сан
Ландмарк төв
Чингисийн өргөн чөлөө 13
14251 Улаанбаатар
info.mongolia@fes.de

Хариуцсан

Доктор Штефани Ханкэ

Холбоо барих

Фридрих-Эбертийн сангийн Монгол дахь салбар
info.mongolia@fes.de

Эх бэлтгэл

Ё.Батболд

Хавтасны зураг

Ё.Батболд

Энэхүү судалгааны агуулга, мэдээллийн үнэн зөв нь Фридрих-Эбертийн-Сангийн байр суурьтай нийцэж байх албагүй болно. Уг бүтээлийн эрх хуулийн дагуу хамгаалагдсан тул тус сангаас бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр болон эшлэлгүйгээр хуулбарлах, олшруулах, хэсэгчлэн авах, ашиглах, арилжааны зориулалтаар хэвлэн нийтлэхийг зохиогчийн эрх зөрчсөнд тооцно.

2024 он

© Friedrich-Ebert-Stiftung e.V.

18-25 насны залуучуудын улс төрчдийг сонгох чиг хандлага

*Фридрих-Эбертийн сангийн
2023-2024 оны тэтгэлэгт
оюутнуудын судалгааны тайлан*

Агуулга

Хүснэгтэн мэдээллийн жагсаалт	6
Зурган мэдээллийн жагсаалт	6
Хавсралтын жагсаалт	6
Удиртгал	7
Сэдвийн үндэслэл	7
Сэдвийн судлагдсан байдал	8
Зорилго, зорилт	9
Нэгдүгээр бүлэг. Онол, үзэл баримтлал	10
1.1 Сонгуулийн нэр томъёоны тайлбар, ойлголт	10
1.1.1 Сонгууль	10
1.1.2 Сонгуулийн тогтолцоо	10
1.1.3 Сонгуулийн тогтолцооны ангилал	11
1.2 Сонгуулийн талаар судалсан эрдэмтдийн онол үзэл баримтлал	13
1.2.1 Рационал сонголтын онол	13
1.2.2 Нийгэм-сэтгэл зүйн хандлага	15
1.2.3 Намыг тодорхойлох онол	17
1.2.4 Социологийн хандлага	18
1.3 18-25 насны залуучуудын онцлог	20
1.3.1 Сэтгэл зүйн онцлог	20
- Залуу нас (12-20) : Эго-адилтгал ба үүргүүд холилдолтын хоорондын зөрчил	20
- Ид насны эхэн үе (20-25): Дотносох ба зожгирахын хоорондын зөрчил	21
1.3.2 Нийгмийн харилцааны онцлог	22
1.4 Монгол Улс болон Олон Улс дахь сонгуулийн ирц, насны бүлгээр	22
1.4.1 Монгол Улсын УИХ болон ИТХ-ын сонгуулийн ирц, насны бүлгээр	22
1.4.2 Бусад улс орны сонгуулийн ирц, насны бүлгээр	24

Хоёрдугаар бүлэг. Судалгааны арга зүй, шинжилгээ, үр дүн	27
2.1 Судалгааны арга зүй	27
2.1.1 Судалгааны асуулт	27
2.2 Шинжилгээ, үр дүн	29
2.2.1 Судалгаанд оролцогчдын мэдээлэл.	29
2.2.2 Статистик үр дүн	33
2.2.2.1 Нэр дэвшигчийн ерөнхий мэдээлэл	33
2.3 Хүчин зүйлийн шинжилгээ	35
2.4 Корреляцийн шинжилгээ	41
2.5 Чанарын судалгаа	42
Дүгнэлт, санал зөвлөмж	43
Судалгааны дүгнэлт	43
Санал зөвлөмж	44
Ном зүй	45
Хавсралт	47
Судалгааны тайлан англи хэл дээр	53

Хүснэгтэн мэдээллийн жагсаалт

Хүснэгт 2.1 Оролцогчдын ерөнхий мэдээлэл	31
Хүснэгт 2.2 Нэр дэвшигчийн насны бүлэг	33
Хүснэгт 2.3 Нэр дэвшигчийн хүйс	34
Хүснэгт 2.4 Нэр дэвшигчийн мэргэжил	34
Хүснэгт 2.5 КМО and Bartlett's Test	35
Хүснэгт 2.6 Хүчин зүйлсийн ачаалал	35
Хүснэгт 2.7 Корреляцийн шинжилгээ	41

Зурган мэдээллийн жагсаалт

Зураг 1.1 Сонгуулийн тогтолцооны ангилал	11
Зураг 1.2 2024 оны ИТХ-ын сонгуулийн ирц /хувиар/	23
Зураг 1.3 2024 оны УИХ-ын сонгуулийн ирц /хувиар/	24
Зураг 1.4 2020 оны Монгол Улсын УИХ-ын сонгуулийн ирц /хувиар/	25
Зураг 1.5 2019 оны Их Британи Улсын сонгуулийн ирц /хувиар/	25
Зураг 1.6 2021 оны Герман Улсын сонгуулийн ирц /хувиар/	25
Зураг 1.7 2022 оны Франц Улсын сонгуулийн ирц /хувиар/	25
Зураг 1.8 2022 оны АНУ-ын КТТ-ын сонгуулийн ирц /хувиар/	26
Зураг 1.9 2020 оны АНУ-ын КТТ-ын сонгуулийн ирц /хувиар/	26
Зураг 1.10 2018 оны АНУ-ын КТТ-ын сонгуулийн ирц /хувиар/	26
Зураг 1.11 2016 оны АНУ-ын КТТ-ын сонгуулийн ирц /хувиар/	26
Зураг 2.1 Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа /хувиар/	29
Зураг 2.2 Судалгаанд оролцогчдын нас /хувиар/	29
Зураг 2.3 Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин /хувиар/	30
Зураг 2.4 Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлт	30
Зураг 2.5 Судалгаанд оролцогчдын харьяалал /хувиар/	30
Зураг 2.6 Судалгаанд оролцогчдын гэрлэлтийн байдал /хувиар/	31
Зураг 2.7 Судалгаанд оролцогчдын сарын орлого /тоогоор/	31
Зураг 2.8 Зан чанар хүчин зүйлийн үр дүн /хувиар/	37
Зураг 2.9 Боловсрол хүчин зүйлийн үр дүн /хувиар/	38
Зураг 2.10 Манлайллын хэв маяг хүчин зүйлийн үр дүн /хувиар/	39
Зураг 2.11 Хувийн замнал хүчин зүйлийн үр дүн /хувиар/	39
Зураг 2.12 Туршлага хүчин зүйлийн үр дүн /хувиар/	40

Хавсралтын жагсаалт

Хавсралт А. Судалгааны асуулга	47
------------------------------------------	----

Удиртгал

Сэдвийн үндэслэл

1992 оны Монгол Улсын анхны ардчилсан сонгууль, 1993 оны Ерөнхийлөгчийн анхны сонгуулийн үеэр сонгуулийн ирц 90 гаруй хувь, орон нутгийн сонгуулийн ирц 70 гаруй хувьтай байсан ба үүнээс хойш сонгуулийн сонгогчдын ирц тогтмол буурсаар иржээ (Үндэсний Статистикийн Хороо, 2021). Сонгуулийн ирц буурахад сонгогчийн боловсрол тааруу, сонгуулийн тогтолцоо, хууль дүрмийн байнгын өөрчлөлт, үүнтэй холбоотой ойлгомжгүй байдал, бухимдал, улс төрийн томоохон намуудын талаарх нийгмийн сөрөг ойлголт, сонгуулийн сурталчилгааны богино хугацаа зэрэг нийтлэг хүчин зүйлс нөлөөлж болох бөгөөд сонгогчдын оролцоо буурч байгаа нь төрд итгэх иргэдийн итгэл буурсан, сонгогчдос албан тушаалтнуудын нийгэм дэх сөрөг дүрээс үүдэлтэй ба энэ нь сонгуулийн шударга байдлыг үгүйсгэж байна (Азийн Сан, 2023).

Сонгогчдын улс төрийн оролцоог насны бүлгээр харьцуулсан дүнг нарийвчлан авч үзвэл 26-аас дээш насныхны улс төрийн оролцоо нас ахихын хэрээр нэмэгдэж байгаа бол улс төрийн оролцооны хувьд бага ирцтэй оролцож байгаа насны бүлэг нь 18-25 насныхан байна (Сонгуулийн Ерөнхий Хороо, 2024). Бид залуу сонгогчдын улс төрийн идэвх бага байгааг мэддэг хэдий ч яагаад бага байгаа шалтгааныг хүн болгон өөр өөрөөр тайлбарлаж байна. Тиймээс бид энэхүү судалгаагаар энэхүү асуудалд тодорхой хариулт өгөхийг зорив.

Залуу сонгогчдын улс төрийн оролцоонд дуу хоолойгоо хүргэж чадахгүй байгаа нь улс орны нийгэм, эдийн засгийн шийдвэр гаргалтад үгүйлэгдэж байгаа бөгөөд олон улсад мөн адил асуудал хэвээр байна (Азийн Сан, 2023). Тэдний улс төрийн оролцоо, ямар улс төрчийг сонгох нь нийгэмд чухал үүрэг гүйцэтгэх юм. Хэрэв тэдний улс төрийн оролцоо нийгэмд тодорхой үүрэг гүйцэтгэж чаддаг бол тэд ямар улс төрчийг сонгохыг илүүд үзэх бол гэсэн асуулт бидний энэхүү судалгааг хийх нэг үндэслэл болсон.

Тиймээс энэхүү судалгаанд бид 18–25 насны залуу сонгогчдын улс төрчдийг сонгох чиг хандлага болон сонгуулийн ирц бага байгаа шалтгаан, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг судлахыг зорив.

Сэдвийн судлагдсан байдал

Иргэдийн нийгмийн тогтолцоонд итгэх итгэл болон улс төрийн оролцооны хамаарлыг судалсан судалгааны үр дүнд урвуу хамааралтай буюу хүмүүсийн нийгмийн тогтолцоонд итгэх итгэл өсөхийн хэрээр улс төрийн оролцоо буурдаг буюу нийгэмд өөрчлөлт хийх эрмэлзэл нь буурдаг байна (Cichocka et al., 2018). Залуучуудын улс төрийн оролцоонд интернэтийн ялгаатай хэрэглээ нөлөөлдөг (Hargittai, & Shaw, 2013) ба санал өгөх цахим уриалга нь сонгуульд санал өгөх нөлөөллийг нэмэгдүүлдэг байна (Jones et al., 2017). Европын 8 орны нийт 2800 залууг оролцуулсан судалгааны үр дүнд залуучуудын улс төрийн сонгуульд оролцох оролцоонд нэр дэвшигчийн улс төрийн имиж бүрдүүлэлт, улс төрийн соёл нөлөөлдөг үр дүн гарсан байна (Furlong & Cartmel, 2011). Түүнчлэн 18-30 насныхны дунд явуулсан судалгаагаар энэ насныхан боловсролын түвшин өндөртэй нэр дэвшигчийг сонгохыг илүүд үздэг байна. (Medenica, 2018). Канад улсад хийгдсэн судалгаагаар 18-29 насны залуучуудын ирц жил ирэх тусам багасаж байгаа бөгөөд үүнд нөлөөлөгч гол хүчин зүйл нь хүсэмжит нэр дэвшигч байдаггүй гэсэн үр дүн гарчээ. (Adsett, 2003). Цаашлаад залуучуудаас улс төрийн манлайлал, манлайлагчийн талаар судалсан судалгааны үр дүнд залуучууд улс төрийн өндөр соёлтой, илтгэх чадвар сайтай улс төрчдийг манлайлагч гэж үздэг байна. (Bastedo, 2014).

Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар (МУЗГХЭГ), Удирдлагын Академи, Конрад-Аденауэр-Сан (КАС) нарын хамтран хийсэн “Залуучуудын улс төрийн оролцоо /18-35 нас/” судалгааны үр дүнгээр улс төрийн үйл явцад оролцож байгаа байдалд дүн шинжилгээ хийхэд залуучуудын 7 хувь нь байнга буюу тогтмол оролцдог, 58 хувь нь зарим үед оролцдог, 35 хувь нь огт оролцдоггүй гэж хариулжээ.

Судлаач Д.Одмаа болон Б.Янжмаа нарын 2020 онд 18-35 насны 1000 залууг оролцуулан хийсэн судалгааны үр дүнд залуучуудын сонгуульд идэвхгүй оролцох хамгийн том шалтгааныг авч үзвэл нийт оролцогчдын 51.5 хувь нь “Хэн ч гарсан ялгаагүй”, 32 хувь нь “Сонгохыг хүссэн нэр дэвшигч байдаггүй” гэсэн үр дүн гарсан байна (Одмаа & Янжмаа, 2020). Улс төрийн сонгуульд хандах шинэ сонгогчийн хандлагыг тодорхойлох судалгаагаар шинэ сонгогчид залуу улс төрчдийг дэмжих хандлага илүү байдаг ба хүйсийн хувьд улс төрд тэгш байдлыг илүү чухалчилдаг үр дүн гарсан байна (Уянга, 2021).

Зорилго, зорилт

Энэхүү судалгаагаар бид Монгол Улсын 18-25 насны залуучуудын улс төрчдийг сонгох чиг хандлагыг судлах ба судалгааны үр дүнд суурилан тодорхой санал, зөвлөмж боловсруулах зорилготой. Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэв. Үүнд:

1. Олон Улсад болон Монгол Улсын хүрээнд 18-25 насны залуучуудын сонгуулийн ирцийг тодорхойлж, нөхцөл байдлыг судална.
2. Монгол Улсын 18-25 насны залуучуудын улс төрчдийг сонгох чиг хандлагын талаар судалгааг асуулгын аргаар авч, үр дүнг боловсруулна.
3. Залуучуудын улс төрчдийг сонгох үйл явцад тулгамдаж буй асуудлыг илрүүлнэ.
4. Залуучуудын сонгуульд оролцохгүй байгаад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох
5. Судалгааны үр дүнд суурилан, дүгнэлт, санал зөвлөмж боловсруулна.

Нэгдүгээр бүлэг.

Онол, үзэл баримтлал

1.1 Сонгуулийн нэр томъёоны тайлбар, ойлголт

1.1.1 Сонгууль

Сонгууль гэж санал өгөх замаар улс төрийн шийдвэр гаргах үйл явцыг хэлнэ. Ардчилсан нийгэмд сонгууль нь төрийн албан тушаалд ажиллах өөрийн төлөөллийг сонгоход сонгогчдын оролцоог удирдах, нийгмийн зөвшилцлийг бий болгох механизм байдаг.

1.1.2 Сонгуулийн тогтолцоо


Сонгуулийн тогтолцоо гэж сонгогч хэдэн саналтай байх, саналаа хэнд өгөх, саналыг ямар аргаар парламентын суудалд хуваарилах зэргийг багтаасан арга, дүрмийг хэлдэг. Сонгуулийн тогтолцоо нь дараах гурван гол үүргийг гүйцэтгэдэг. Нэгдүгээрт, сонгогчдын өгсөн саналд үндэслэн нам, нэр дэвшигчдийн суудлын тоог тогтоох, хоёрдугаарт, иргэд сонгосон төлөөлөгчидтэйгөө хариуцлага тооцох хэрэгсэл, гуравдугаарт, эрх мэдлийн төлөө өрсөлдөгчид сонгогчидтойгоо харьцах арга замыг сонгох хөшүүрэг болдог. Гэхдээ ихэнх судлаачид сонгуулийн тогтолцоо нь сонгуулийг хэрхэн зохион байгуулахыг тодорхойлсон ерөнхий ойлголт бөгөөд тойрог ямар байх, сонгогч саналаа яаж өгөх, намуудын кампанит ажлын стратеги ямар байх, нэр дэвшигч хэн байх, намын бодлого ямар байх, сонгогчдын саналыг хэрхэн татах, авсан саналыг парламентад хэрхэн хуваарилах зэрэг олон асуудлыг багтаасан ойлголт гэж тайлбарладаг. Тиймээс сонгуулийн тогтолцоо бол өргөн хүрээтэй, улс төрийн тогтолцоонд нөлөөлдөг чухал асуудал юм. Судлаач Райллигийн тодорхойлсноор сонгуулийн тогтолцоо нь “сонгуульд өгсөн аливаа саналыг парламент, эсвэл бусад албанд хэрхэн суудал болгохыг заасан журам, үйл ажиллагаа” юм. Сонгуулийн тогтолцоо нь институтийн дараах гурван чухал үүргийг гүйцэтгэдэг болохыг Райлли тэмдэглэжээ:

1. Сонгуулийн тогтолцоо нь сонгогчдын саналыг хууль тогтоох байгууллагад суудал болгон хувиргах,
2. Сонгуулийн тогтолцоо нь сонгогдсон төлөөлөгчдөдөө хариуцлага тооцох,

3. Сонгуулийн тогтолцоо нь эрх мэдлийн төлөө өрсөлдөж байгаа хүмүүст өрсөлдөөний тактик боловсруулахад нь туслах.

1.1.3 Сонгуулийн тогтолцооны ангилал

Зураг 1.1 Сонгуулийн тогтолцооны ангилал



Эх сурвалж: Судлаач Райлли болон IIDEA байгууллагын гаргасан ангилал

Улс төрийн шинжлэх ухаанд ардчилсан сонгуулийн тогтолцоог үндсэн хоёр гол тогтолцоонд хуваан авч үздэг. Эдгээр нь ялалт байгуулж буй хувь хэмжээний ялгаанаас үл хамааран ялагч нь бүгдийг авдаг олонхын буюу мажоритар болон авсан саналын хувь хэмжээгээр улс төрийн намуудад суудал хуваарилдаг пропорциональ буюу хувь тэнцүүлсэн тогтолцоо юм. Энэхүү өргөн хүрээний ангилал дотроо сонгуулийн тогтолцоонуудыг олон хуваан авч үзэх ба сонгогчдын саналыг хэрхэн хууль тогтоох байгууллага дахь суудал болгож буйгаас нь шалтгаалан олонх, дийлэнхийн тогтолцоо мажоритар (plurality/majority), хувь тэнцүүлэх тогтолцоо- пропорциональ систем (proportional- PR), холимог систем (mixed) болон бусад систем хэмээн дахин ангилна. Хамгийн түгээмэл сонгуулийн тогтолцоонууд болон эдгээрийн хоорондын ялгаатай байдалд дараахыг багтаан үзэж болно.

1. Дийлэнх/олонхын тогтолцоо (Majoritarian system): Энэ тогтолцоо

нь түгээмэл хэрэглэдэг таван хувилбартай. Үүнд олонхын (plurality) буюу нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан хүн ялах дүрэмтэй харьцангуй олонхын (First past the post-FPTP), багц саналын (Block voting-BV), дийлэнх (majoritarian system) буюу үнэмлэхүй олонхын гэгддэг нийт хүчинтэй саналын талаас илүү буюу 50+1% хувийн санал авсан нэр дэвшигч ялах дүрэм үйлчилдэг хоёр шаттай тогтолцоо (Two round-TRS), алтернатив (Alternative vote-AV) болон намын багц санал (Party block vote-PBV) тогтолцоо тус тус багтана.

2. Хувь тэнцүүлэх тогтолцоо (Proportional system): Хувь тэнцүүлэх тогтолцооны зорилго нь намын авсан саналыг хууль тогтоох байгууллагын суудалд зориудаар хувь тэнцүүлэн хөрвүүлэхэд оршдог. Хувь тэнцүүлэх тогтолцооны үндсэн хоёр хувилбарт намын жагсаалт (List PR), шилжих дан санал (Single transferable vote-STV) зэрэг тогтолцоо тус тус багтана. Дээрх бүх хувилбарт сонгуулийг улс - нэг тойргоор зохион байгуулдаг.

3. Холимог тогтолцоо (Mixed system): Холимог тогтолцоог дийлэнх/олонхын болон хувь тэнцүүлэх тогтолцооны аль алиных нь шинжүүдийг нэгтгэх оролдлого хэмээн ойлгож болно. Холимог тогтолцоо нь өөр өөр томьёололтой сонгуулийн хоёр тогтолцоог зэрэгцүүлсэн (Parallel system-PS) буюу сонгогчид хоёр, эсвэл үүнээс дээш тооны санал өгч, энэ нь сонгуулийн олонхын болон хувь тэнцүүлсэн хэсэгт тус тусад нь тооцогддог тогтолцоо болон холимог (Mixed Member Proportional-MMP) буюу сонгогч нь нэг мандаттай тойргийн нэр дэвшигчид санал өгч, хамаарах улс төрийн намд өгсөн саналын хувь хэмжээг мөн тооцон суудал хуваарилдаг тогтолцоо гэсэн хоёр хувилбартай.

4. Бусад: Сонгуулийн дийлэнх/олонхын болон хувь тэнцүүлэх аргуудаас өөр үл шилжих дан санал (Single non-transferable vote-SNTV), хязгаарлагдмал санал (Limited vote-LV), Борда санал (Borda count-BC) гэсэн аргуудыг багтаадаг.

1.2 Сонгуулийн талаар судалсан эрдэмтдийн онол үзэл баримтлал

1.2.1 Рационал сонголтын онол

Энэхүү онол нь хувь хүмүүс өөрсдөдөө гарах зардал, үр ашгийг оновчтой тооцоолсны үндсэн дээр санал өгөх шийдвэр гаргахыг санал болгодог. Сонгогчид хувийн ашиг сонирхолд нийцсэн гэж үздэг бөгөөд нэр дэвшигчид эсвэл хувийн ашиг тусаа нэмэгдүүлэх бодлогыг сонгохыг зорьдог (Timothy, 2004). ХХ зууны нийгмийн хувьсал өөрчлөлтийг онолын сэтгэлгээ хөөн гүйцэж тайлбарлахад туйлын хэцүү байсан байна. Тиймээс шинжлэх ухааны бүхий л салбарт шинэ онолын чиглэлүүд шил шилээ даран гарч байв. Чухам энэ үйл явцын дунд сонгогчийн зан үйлийг тайлбарлах рационал сонголтын онол үүсжээ. Рационал сонголтын онол хөгжихөд дараах хэд хэдэн хүчин зүйлс нөлөөлсөн гэж үзэж болно. Үүнд:

Нэгдүгээрт. 1960-1970-аад оны үеэс эхлэн нийгмийн шинжлэх ухааны арга зүйд ноёрхож байсан бихевиорист болон бүтэц үүргийн шинжилгээ нь учир дутагдалтай болж эхэлжээ. Тиймээс судлаачид цаашид судалгааны ажлаа ахиулахын тулд шинэ онол арга зүйн эрэл хайгуул хийхэд хүрсэн. Чухам энэ нүсэр ажлын үр дүнд бий болсон онолын чиглэл бол рационал сонголтын онол юм. Судлаачдын үзэж байгаагаар рационал сонголтын онол нь бихевиоризм болон бүтэц үүргийн шинжилгээ ба институцчлах хандлагын сул талуудыг даван гарч чадсан гэж үздэг. Мэдээж зарим судлаачид рационал сонголтын онол нь нийгмийн шинжлэх ухааны хүрээнд эрт дээр үеэс сэтгэл ханамжит байдал руу тэмүүлэх зэрэг зарим нэг санааг судлаачид уг онолын эх үндэс хэмээн онцолдог.

Хоёрдугаарт. Рационал сонголтын онол нь эдийн засгийн шинжлэх ухаанд үр хөврөлөө тавьж бие даасан салбар болж чадсан байна. Ялангуяа, барууны улс төр эдийн засгийн ухааны онолын хүрээн дэх неоклассик онолын үндсэн ойлголтууд болох “хүний эрх чөлөө”, “хувь хүний сонголт”, “хувь хүний рационал байдал” зэрэг дээр тулгуурлан бие даасан онол болж чадсан юм. Сүүлдээ дан ганц эдийн засгийн ухаанаас халин гарч нийгмийн ухаанд нэвтрэн орж ирсэн. Энэ нь зорилго чиглэлтэй үйлдлийн загвар бөгөөд нийгмийн бүхий л шинжлэх ухаанд хэрэглэгддэг, нийгмийн үйлдлийн тодорхой зорилгод хүрэх эрмэлзэл, эл үйлдлээрээ ашигтай үр өгөөжтэй үр дүнд хүрэхийг эрмэлзэж байдагт оршдог.

Гуравдугаарт. Рационал сонголтын онол гэсэн ойлголт нь өөртөө олон янзын ойлголтуудыг багтааж байдаг. Тухайлбал социал сонголтын онол, тоглоомын онол, рационал тоглогчдын онол, улс төр дэх эдийн засгийн хандлага, улс төр эдийн засгийн ухаан гэх мэт. Энэ нь уг онолын чиглэлийн өргөн цар хүрээтэй гэдгийг харуулж байгаа хэрэг мөн. Улмаар рационал хандлага нь улс төрийн формал онолын хүрээнд хүчтэй хөгжиж эхэлжээ. Улс төрийн формал онолыг ердийнхөөр тодорхойлбол зах зээлийн биш нөхцөлд рационал сонголтууд ба тэдний үр дүнд цогц байдлаар шинжилгээ хийх явдал юм. Өөрөөр хэлбэл, индивидуаль сонголтын талаар төсөөлөл юм хэмээн бичсэн нь бий.

Энэхүү онолын гол төлөөлөгч нь Э.Даунс бөгөөд тэрээр “Иргэн бүр өөрт нь бусад намуудаас илүү ашигтай гэж санагдсан тэр намын төлөө саналаа өгдөг” гэсэн үндэслэлийг гол болгодог (Sanders, 2011). Сонгогчид тухайн нам өөрт нь ашигтай гэдгийг намын мөрийн хөтөлбөрөөр дамжуулан мэддэг хэмээн тэрээр үзжээ. 1950-иад онд боловсруулсан ардчиллын үр ашгийн онолдоо Э.Даунс хувь хүний шийдвэр гаргахдаа тооцож үздэг хүчин зүйлсийг чухалчлан авч үзсэн байдаг. Тэгэхдээ хувь хүний сонгуулийн үеэр гаргах шийдвэр нь улс төрийн хувьд гаргаж болох хамгийн их ашгаар тодорхойлдог. Рационал сонгогч нь ийнхүү өөрт нь хамгийн их ашигтай тусдаг бодлого бүхий намын төлөө саналаа өгдөг.

Э.Даунсын судалгаанд хэрэглэгддэг рационал сонголтын ойлголт нь гэхдээ хэзээ ч үйл ажиллагаа явуулж буй хүний зорилгыг бус харин ямагт гагцхүү байж байгаа хэрэгслийн ашиглалт өөрөөр хэлбэл өөрийнх нь сонгож авсан үнэлэмжийнхээ үүднээс дүгнэж цэгнэсэн эдийн засгийн хувьд үр ашигтай (рационал) тусгах замыг иш үндэс болгодог. Энэ утгаараа рационал хүн эхлээд өөрийнхөө өмнө тавьсан зорилгодоо хүрэхэд хэрэгжүүлэх алхмынхаа хувилбарыг дараалуулан үздэг. Тэгээд тэдгээрээсээ хамгийн үр ашигтай хувилбарыг сонгож аваад нөхцөл нь ижил байх тохиолдолд байнга ижил үр дүнд хүрдэг. Рационал гэдгийг ийнхүү ойлгох нь рационал байдлын талаарх хэвшмэл төсөөллөөс ихээхэн ялгаатай. Сонгуулийн талаарх шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаанд сонгогчийн үйл байдлыг үндсэндээ улс төрийн тулгамдсан маргаантай асуудлын талаар сонгогчийн баримталж буй байр суурьтай адилтган авч үздэг. Рационал сонгогч нь сонгуульд өгөх саналаа үр ашгийн тооцоо хийж гаргадаг, ингэхдээ тэрээр засгийн гарын өнгөрсөн бүрэн эрхийн хугацааны үйл

ажиллагааг сөрөг хүчин засгийн эрхэнд байсан бол хийх боломжтой байсан ажилтай харьцуулж үздэг. Үүний үндсэн дээр тэрээр өөрийнх нь хувийн зорилгуудыг хамгийн түрүүнд хэрэгжүүлж чадна гэж үзсэн намын төлөө саналаа өгдөг. Онолын энэхүү хоёр байр сууринаас гарсан дүгнэлтээс сонгуулийн явцад цаг үеийн ялангуяа эдийн засгийн тодорхой асуудлыг тандсан нарийвчилсан судалгаанууд их хэмжээгээр хийгдэх болсон (Melvin & Pollard, 1981).

Гэхдээ мөн рационал загвар ч өөрийн сул талтай. Уг загварын хүрээнд тавигдаж буй асуудлын дотор хүн ер нь ямар учраас сонгуульд оролцдог вэ? гэсэн асуултыг тодорхой хариулж болохгүй байгаа юм. Хувь хүний өгсөн саналын нөлөө, өөрөөр хэлбэл сонгуульд оролцсоноос олсон ашиг нь гарсан зардал хүчин чармайлтаас хавьгүй бага юм. Түүнчлэн чухам ямар учраас засгийн газрыг бүрдүүлэхэд оролцох боломж байхгүй жижиг намын төлөө саналаа өгдөг болохыг хангалттай тайлбарлаж чадахгүй байгаа юм.

1.2.2 Нийгэм-сэтгэл зүйн хандлага

Нийгэм-сэтгэлзүйн загварыг гаргасан Мичиганы их сургуулийн судлаачид юүлүүрэн хоолойн үзэл баримтлалаар сонгогчийн зан үйлийг тайлбарладгаараа алдартай юм. Тэдний юүлүүрэн хоолойн үзэл баримтлалыг судлаач Г.Ричард Нэйми болон Херберт Ф.Вейсберг нар хураангуйлан тайлбарласан бөгөөд юүлүүрийн дээд хэсэг нь буюу нарийн үзүүр нь сонгуульд саналаа өгөх үйл явц юм. Сонгогч сонгуульд саналаа өгөх нь тухайн хүний амьдралд урьд өмнө болж өнгөрсөн олон хүчин зүйлээс шалтгаалдаг. Юүлүүрийн тэнхлэг дагуу хөндлөнгөөрөө (амсраасаа нарийн үзүүр хүртэл) бол цаг хугацаа оршино. Тухайн хүний амьдралд тохиолдсон үйл явдлууд нэг нь нөгөөгөө дагалдан, учир шалтгааны цуваа болон нэгдэж, нэг шинж болон юүлүүрийн амнаас нь үзүүр хүртэл урсана. Ийм маягаар үй түмэн шалтгаанууд нарийсаж (нэгдэн) санал өгөхөд хүргэдэг. Юүлүүрийн аманд буюу эхэнд байгаа хүчин зүйлсийг нэгд социологийн шинж чанарын туршлага, хоёрт социал статус түүнтэй холбоотой шинж чанарын туршлага, гуравт гэр бүлийн шинж чанарын туршлага гэж гурван үндсэн хэсэгт хуваан үзжээ. Юүлүүрийн амны нэг захад социологийн шинж чанаруудын туршлагад (яс үндэс, арьс өнгө, амьдран суугаа дүүрэг, шашин г.м. хүчин зүйлийг) оруулсан, харин дунд нь социал статусын шинж чанарын туршлагад (боловсрол, ажил эрхлэлт, анги зэрэг хүчин зүйлсийг) оруулсан бол доод захад нь гэр бүлийн шинж чанарын туршлага (анги, нам,

дэмжигчид) байрлажээ. Намын харьяалал нь цаашаагаа тодорхой асуудлаарх иргэдийн байр суурь ба нэр дэвшигчийн талаарх бие хүний үнэлгээнд шууд нөлөөлнө. Энд сонгуулийн кампанийн үйл явдлууд (сонгуулийн сурталчилгаа, нэр дэвшигчдийн халз ярилцлага, мэтгэлцээн зэрэг) явагдана. Үзүүрийн наана нь сүүлийн хэсэгт сонгогчийн сонгуулийн талаарх гэр бүл болон найз нөхөдтэй хийсэн ярилцлага нөлөөлнө. Тэгээд эцэст саналаа өгнө.

Мөн юүлүүрэн хоолойг судлаач П.Доржсүрэн учир шалтгааны хоолой хэмээн нэрлээд дараах байдлаар тайлбарлажээ (Ганболд, 2014). Хоолойн өргөн талд нийгэм дэх улс төрийн ялгаа, зөрчилдөөнийг нөхцөлдүүлэгч нийгэм эдийн засгийн хүчин зүйлсийг байрлуулжээ. Эдгээр нь сонгогч сонгуульд эцсийн шийдвэр гаргахад тэр бүр шууд нөлөөлдөггүй, алсаас дам үйлчилдэг. Нийгэм, эдийн засгийн нөхцөл нь иргэн өөрийгөө социал аль бүлэгт хамаатуулан үздэг хийгээд түүний үнэт зүйлсийн чиг баримжаалалд нөлөөлнө. Бүлгийн хамаарал, үнэт зүйлсийн чиг баримжаалал нь улс төрийн байр суурьтай холбогдон улс төрийн сонголтод шууд нөлөөлнө. А.Кэмбелл хувь хүний санал өгөх үйлийг гурван төрлийн байр суурь (намын харьяалал буюу түүнийг дэмжих байдал, бодлогын чухал асуудал, нэр дэвшигчийн талаар баримталж буй байр суурь)-тай юуны өмнө холбон, эдгээр байр суурь, итгэл үнэмшил нь сонголт хийхэд шууд, маш хүчтэй нөлөөлнө гэж үзжээ.

Түүнчлэн нийгэм-сэтгэл зүйн загвар нь сэтгэл хөдлөлгүй (экспрессив) байдлаар авч үздэг ч сонгогчдод саналаа өгөхөд нь нийгмийн томоохон бүлэг биш хөрин улс төрийн нам нөлөөлдөг гэж үздэг. Нөлөөлөл нь сонгогч өөрийгөө улс төрийн тодорхой нэг намд харьяалуулж үзэх явдал бөгөөд энэ нь улс төрийн нийгэмшилтээр дамжин явагддаг. Хэдийгээр нийгэм-сэтгэлзүйн загвар нь судалгааныхаа хүрээнд сэтгэл хөдлөлгүй байдлаар авч үздэг ч сонгогчдод саналаа өгөхөд нь нийгмийн томоохон бүлэг биш харин улс төрийн нам нөлөөлдөг гэж үздэг.

Гэвч нийгмийн статусыг нь сонгогчдод хуваарилах эсвэл намтай адилтгах гэсэн хоёр концепцоор сонгогчдын эрхэмлэгээг тодорхойлоход зарим бэрхшээл хязгаар бий болсон. Энэ дутагдал нь 1970-аад оны үед сонгогчид уламжлалт улс төрийн намууд холдох аль нэг ангид харьяалагдаж байгаа нь сонгуульд саналаа өгөхөд шууд нөлөөлөхөө больсон зэргээр илрэлээ олсон. Сонгогчдын

“сэтгэл хөдлөлгүй” зан үйлд гол болгодог дээрх онолууд судалгааны шаардлагыг бүрэн хангахаа больсон учраас судлаачид өөр аргыг эрэлхийлж эхэлжээ. Нийгэм-сэтгэл зүйн загварт сонгогчийн зан үйлд гадна орчны үзүүлэх нөлөө мөн тусгагдсан байна. Сонголтын учир шалтгааныг ойлгоход түүнд нөлөөлж буй хүчин зүйл нэг бүрийн гүйцэтгэх үүрэг, хоорондын харилцан холбоо, хамаарлыг зөв тогтоох явдал хамгаас чухал гэдэг нь ойлгомжтой.

Нийгэм-сэтгэл зүйн онолыг зарим судлаачид цааш улам баяжуулан тайлбарласан байдаг. Үүнд Дональд Стоуксын өргөтгөсөн загварыг дурдаж болно. Энэ загвар ерөнхийдөө нийгэм-сэтгэл зүйн онолд хамаарах боловч сонгогчдын зан үйлийг тайлбарлах зарим нэгэн ойлголтыг шинээр дэвшүүлсэн. Үүнд нэгдүгээрт нам ба нэр дэвшигчийн дотоод ба гадаад бодлого, хоёрдугаарт намууд ба менежерүүдийн ашиг олох явдал дээр үндэслэсэн үйл хэрэг (ажил хийдэг эрэгтэйчүүд ба фермерүүд г.м), гуравдугаарт нэр дэвшигчийн хувийн салшгүй шинж ба стиль зэрэг нь сонгогчдын хандлагад нөлөөлдөг гэж үзжээ. Харин судлаач Филифф Е.Конверс массын итгэл үнэмшлийн системийн мөн чанарыг судлаад ихэнх америкчуудын хувьд намыг дэмжигч байх мөн нэр дэвшигчдийн имиж чухал гэдгийг харуулсан байна. Нийгэм-сэтгэлзүйн онол нь санал өгөхөд зөвхөн социал хүчин зүйлсээс гадна улс төрийн хүчин зүйлс, бусад хүчин зүйлсэд харгалзан үзсэнээрээ ололт гэж үздэг. Мөн сонгогчийн зан үйлд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг цаг хугацааны хувьд ангилан үзсэн ач холбогдолтой гэж судлаачид тэмдэглэдэг. ХХ зууны дунд үе гэхэд нийгэм-сэтгэл зүйн онол ардчилал өндөр хөгжсөн одон орны сонгогчийн зан үйлийг судлахад хэрэглэснээр улам баяжин хөгжжээ.

1.2.3 Намыг тодорхойлох онол

Энэ онол нь сонгогчийн намын харьяалал нь тэдний санал өгөх зан төлөвийг тодорхойлох хамгийн чухал хүчин зүйл гэж үздэг. Хувь хүмүүс аль нэг улс төрийн намтай адилтгасан бол тухайн намаас нэр дэвшигчдэд саналаа өгөх нь тухайн нэр дэвшигчдийн тодорхой бодлогын мөрийн хөтөлбөрөөс үл хамааран илүү өндөр байдаг. Өөрөөр хэлбэл, бодит байдалд нийцэж байгаа эсэхээс үл хамааран тухайн намыг өөрийн чухал үнэт зүйл болгодог. Үүнийг“намд харьяалуулах” (party identification) хэмээн үздэг. Намыг тодорхойлох нь санал өгөхөд нөлөөлдөг чухал хандлага юм. Ихэнх сонгогчид улс төрийн хоёр том намын аль нэгтэй нь холбоотой байдаг бөгөөд

эдгээр үндсэн намын үнэнч байдал нь санал өгөхөд нөлөөлдөг. Намын тодорхойлолтыг ихэвчлэн ардчилсан, Бүгд найрамдах нам эсвэл бие даагч гэж үздэг хүмүүсээс асууж хэмждэг. Дараа нь Ардчилсан эсвэл Бүгд найрамдах намыг зааж буй хүмүүсээс хүчтэй эсвэл сул Ардчилсан эсвэл Бүгд найрамдах намын аль нь болохыг асуудаг бол бие даагч гэж мэдэгдэж байгаа хүмүүсээс улс төрийн хоёр намын аль нэгэнд илүү ойр байгаа эсэхийг асуудаг. Энэ нь хүчтэй Ардчилсан намынхан, сул Ардчилсан намынхан, Ардчилсан намд ойр бие даагчид, аль ч намд ойр биш бие даагчид, Бүгд найрамдахчуудад илүү ойр бие даагчид, сул Бүгд найрамдахчууд, хүчтэй Бүгд найрамдахчууд гэсэн долоон ангилалтай. Энэхүү долоон онооны намыг тодорхойлох хуваарь нь мэдээллийн багцад байна. Ерөнхийлөгчийн сонгуульд намыг тодорхойлох шууд нөлөөлөл бага байна. Зөвхөн Буш Бүгд найрамдах намын гишүүн байсан учраас л маш цөөхөн сонгогчид түүнд санал өгсөн байх. Гэхдээ намыг тодорхойлох шууд бус нөлөө нь маш их, учир нь намуудын үнэнч байдал нь нэр дэвшигчдийн үнэлгээ, засгийн газрын үйл ажиллагааны үнэлгээ, улс төрийн үйл явдлын талаарх ойлголтод нөлөөлдөг. Энгийнээр хэлбэл, намыг таних нь сонгогч улс төрийн ертөнцийг хардаг намын өнгөт нүдний шил гэсэн ойлголттой дэлгэц юм. Намыг тодорхойлох нь өмнөх үетэй харьцуулахад арай бага ач холбогдолтой байж болох ч энэ нь улс төрийн чиг баримжаа, зан үйлийг тайлбарлахад маш чухал хүчин зүйл хэвээр байна (Abramson, Aldrich, and Rhode 2003, 168-191).

1.2.4 Социологийн хандлага

П.Лазерсвельд болон хамтрагчид хувь хүний шүтдэг шашин, социал холбоо (social relation), хувийн туршлага (personal background) зэргийг судалж үзсэн. Дараах гурван хүчин зүйлс буюу нэгдүгээрт, хувь хүний шашин шүтлэг, хоёрдугаарт, социал статус, гуравдугаарт, оршин суугаа газар зэрэг нь сонгогчийн сонголтыг урьдчилан хэлэхэд туйлын чухал гэж тэд үзсэн байна. Жишээлбэл, католик шашинтнууд Ардчилсан нам руу, Протестант шашинтнууд БНН-д санал өгөх хандлагатай байхад, нийгмийн давхраажилтад доогуур байр суурьтай (доод статустай) хүмүүс Ардчилсан намд, дээд статустай хүмүүс БНН-руу саналаа өгч байв. Мөн хөдөөгийн иргэд БНН-руу, харин хотын оршин суугчдын ихэнх нь Ардчилсан намд талтай нь нотлогдсон. Ингэж санал өгөлтийг шашин, социал статус, оршин суугаа газар гэсэн гурван хүчин зүйлтэй холбон индексжүүлснээр сонгогчдын саналыг урьдчилан хэлж болно гэдэг нь тэдний судалгаагаар батлагджээ. Жишээлбэл,

нийгэмд дээд статустай хүмүүс зонхилдог, (дөрөвний гурав нь) хөдөө орон нутагт оршин суудаг, протестант шашинтай тийм газарт БНН-ыг илүү дэмжлэгтэй байсан. Гэхдээ эдгээр хүчин зүйлс өөр хоорондоо зөрчилдсөн тохиолдолд яадаг вэ? гэсэн асуулт зүй ёсоор урган гарчээ. Үүний хариулт ч гэсэн нарийн төвөгтэй болзмол шинжтэй байх нь ойлгомжтой. П.Лазерсвельд иргэдийн улс төрийн сонирхлыг судалж байх явцдаа зарим хүмүүс “давхар дарамтад” байдаг болохыг илрүүлжээ. Энэ нь тухайн сонгогчийн нэг хүчин зүйл нь БНН-ын төлөө санал өгч магадгүйг харин нөгөө хүчин зүйл нь Ардчилсан намд талтай байгааг харуулна. Ийм байдалд орсон сонгогчийг давхар дарамтад орох гэж судлаачид нэрлэсэн. Тэд сонгуулийн өдөр болоход алтернатив хандлагаас аль нэгийг нь сонгоход хүрнэ. Эс бөгөөс зарим нь саналаа өгөх нь бүү хэл сонгуулийн компанийг бүхэлд нь сонирхохоос татгалзаж сэтгэл зүйн хувьд хөндийрч эхэлдэг. Ийм нөхцөл байдалд орсон сонгогч сонголт хийхдээ илүү их мэдээлэл эрж хайхад хүрдэг гэсэн дүгнэлтэд тэд хүрсэн. Судлаачид хэвлэл мэдээллийн хэрэгслээр сонгуулийн талаарх мэдээлэл сонгогчдод илүү хүрдэг хэмээн ойлгож байв, гэтэл бодит байдал дээр тэдний өөрсдийн найз нөхөд, ажлын холбоо сүлбээ, гэр бүлийн хүмүүсээс авсан зөвлөгөө илүү нөлөөлдөг нь тогтоогджээ.. Чухам үүн дээр тулгуурлан П.Лазерсвельд “харилцаа холбоог урсгах 2 шат” гэсэн ойлголтыг гаргаж ирсэн. Энэ нь нам бүр өөрийн нэр дэвшигчийг өөрсдийн намын идэвхтэн, гишүүдээр дамжуулан мэдээлэл цацах кампанит ажлыг явуулах ба намын идэвхтэн, дэмжигчид, намын мессежийг бусдад түгээх үүрэгтэй аж.

Өрнөдийн орнуудад төлөвшсөн улс төрийн намын систем ба түүнд таарч тохирсон сонгогчдын сонголтын бүтцийн “гарвал зүйн загварыг” С.М.Липсет, С.Роккан нар үндэслэсэн нь сонгогчдын зан үйлийн социологийн онолыг хөгжихөд чухал үүрэг гүйцэтгэсэн. С.М.Липсет, С.Роккан нар сонгуульд хүчтэй нөлөө үзүүлдэг дөрвөн үндсэн зөрчлийн хэв маягийг гаргасан бөгөөд энэ нь төв болон зах хязгаар, төр болон сүм хийд, хот болон хөдөө, хувийн өмчтөн болон ажилчин нарын хоорондын ялгаанаас үүдэлтэй ажээ. Эдгээр ялгаа бүр нь нийгэмд нам болон нэр дэвшигчийг дэмжих бүтцийг тодорхойлсон тийм хагарлыг (зөрчлийг) бий болгодог байна. Чухам эл онолыг генетик загвар гэж нэрлэх нь бий. Сонгогч яагаад аль нэг социал хүчин зүйлсээ харж саналаа өгдөг вэ? Үүнд судлаачид хариулахдаа санал өгнө гэдэг нь иргэдийн чөлөөтэй улс төрийн хүсэл зоригоо илэрхийлэх явдлаас илүүтэй бие хүн бүлэгтэйгээ эв нэгдэлтэй байгааг харуулсан хэрэг гэж тайлбарласан байдаг. Тухайлбал, католик шашинтай хүн улс төрийн

сонголт хийхдээ бусадтайгаа зөрж санал өгөх нь ховор тохиолдоно. Тиймээс нийгмийг ялгарлын хүчин зүйлийн зөрчлөөр, сонгогчийн социал шинж чанараар авч үздэг нь социологийн хандлагын онцлог юм. Өөрөөр хэлбэл, нийгэм дэх томоохон бүлгүүдийн зөрчил тэмцэл нь сонгуулиар илэрч буй хэрэг ажээ. Чухамдаа К.Марксын судалж байсан капиталист нийгмийн анги, бүлгүүдийн зөрчилдөөн нь эдийн засаг, аж үйлдвэрийн салбарын менежмент, төрийн зохистой бодлого, үйлдвэрчний эвлэлийн идэвхтэй үйл ажиллагаа зэрэгтэй уялдан багассан. Ингэж нийгэм дэх ялгарлын хүчин зүйлс өөрчлөгдөх болсон нь эдгээр хүчин зүйл улс төрийн сонголтыг шууд тодорхойлогч байж чадахаа болиход хүрсэн. Энэ үйл явцтай уялдан сонгогчийн зан үйлийг тайлбарлах нийгэм-сэтгэл зүйн хандлага үүсэн бий болжээ.

1.3 18-25 насны залуучуудын онцлог

1.3.1 Сэтгэл зүйн онцлог

Судлаач Э.Эриксоны Психо-социал хөгжлийн онолдоо 12-20 насыг залуу нас, 20-25 насыг ид насны эхэн үе гэж ангилан авч үзсэн байдаг.

Залуу нас (12-20) : Эго-адилтгал ба үүргүүд холилдолтын хоорондын зөрчил

Энэ насанд гарч ирж буй хөгжлийн эерэг үзүүлэлт нь эго-адилтгал юм. Энэ нь өөрийгөө тодорхойлох, өөртэйгөө өөрийгөө адилтгах гэсэн утгатай. Энэ үеийн хөгжлийн сөрөг үзүүлэлт нь үүргийн холилдолт юм. Өсөн хөгжиж физиологийн дотоод хувьсалд орж буй залуучууд өөрийн нийгмийн үүргээ бэхжүүлэхийг эн тэргүүнд тавьдаг. Өөрийн талаарх өөрийн төсөөлөл ба орчны хүмүүсийн нүдэнд бууж буй төрх хоёрын харьцаа, өмнө нь өөрт нь бий болсон туршлага, гүйцэтгэж ирсэн үүрэг ба яг өнөөдөр төсөөлөгдөж буй идеал дүр хоёрыг хослуулах асуудал дээр энэ насныхан маш эмзэг ханддаг. Эриксон эго-адилтгалыг тодорхойлохдоо доорх гурван зүйлийг анхаарсан байна. Үүнд:

- Залуучууд “өөрийгөө өөртэйгөө адилтгасан дотоод адилтгалыг” тогтмол мэдэрч байх ёстой.
- Ойр дотнын хүмүүс тэдний энэхүү дотоод адилтгалыг олж харсан байх нь чухал. Миний талаарх миний төсөөллийг бусад хүмүүс

хүлээн зөвшөөрч байна гэсэн итгэл залуучуудад бий болох нь ихээхэн ач холбогдолтой юм. Хэрвээ тэдний “Би”-г олж харж чадахгүй бол ичих, эргэлзэх, гутрах сэтгэл үүсдэг байна.

- Өөрийн талаарх цогц төсөөлөл дотоод гадааддаа зохицолдож байна гэсэн итгэл мэдрэмж нь залуучуудад улам бүр өсөж нэмэгдэж байх нь чухал. Өөрийгөө таньж, хүртэж буй тэдний ойлголт төсөөлөл бусад хүмүүстэй харилцах харилцаагаар дамжин илрэх урвуу холбоогоор батлагдаж байх ёстой.

Хэрвээ нийгэм, гэр бүл зэрэг бусад зүйлийг, тэдний үзэл суртлыг залуучууд хүлээн авч чадахгүй бол туйлын төсөөллийн сарнилт үүснэ. Ийнхүү гадаа ба дотоод адилтгалын зөрчил үүсдэг байна. Ийм зөрчил үүсэхэд орчны доорх хүчин зүйлүүд нөлөөлдөг гэжээ.

- Нийгмийн хүрээллийн нөлөө маш чухал ба одууд, түүхэн хүмүүстэй өөрийгөө хэт адилтган төсөөлөх нь тэдэнд дөнгөж бүрэлдэж байсан адилтгалын дүр төрхийг нь сарниулан тасалж би хаана нь ч хүрэхгүй гэсэн дарамтыг учруулдаг.
- Улс төр, нийгэм технологийн эрс өөрчлөлтүүдийн улмаас энэ үеийнхэнд түгшүүр үүсдэг (Батболд, 2020).

Ид насны эхэн үе (20-25): Дотносох ба зожгирахын хоорондын зөрчил

Энэ насныхан бусадтай харьцах ойр дотно харилцаанд ороход нийгмийн талаас гарч ирж буй ололтууд нь маш чухал. Нийгмийн хүрээний ололт амжилтууд нь хүний ёс суртахууны мэдрэмж бүрэлдэн тогтоход ихээхэн нөлөөтэй юм. Удаан хугацааны үерхэл нөхөрлөл, нийгэмд гүйцэтгэж буй үүргийнхээ үнэ цэнийг ойлгон ухаарсан тэр үеэс хүнд ёс суртахууны мэдрэмж бий болдог. Энэ бүхний ачаар хүн эрхэм нандин зүйлийнхээ төлөө өөрийгөө золиослоход бэлэн байдаг.

Энэ үед дотно харьцаа нь олон талтай өргөн хүрээтэй асуудал болдог. Нэг талаас өөрөө юу ч алдана гэж айхгүйгээр, өөрийгөө бусадтай адилтгах, нөгөө талаас хайр сэтгэл, бэлгийн харилцаанаас гадна чин сэтгэлийн нөхөрлөл итгэлийг багтаана. Бусдад итгэж, бусадтай дотносох нь хүн өөрийгөө хэр зэрэг таньснаас шалтгаалах бөгөөд өөрийн талаар тогтвортой төсөөлөл үүсээгүй бол бусадтай жинхэнэ ёсоор дотносож чадахгүйд хүрдэг. Эриксоны үзсэнээр, хөгжлийн эерэг тал нь хайр сэтгэл юм. Харин өөрийн бодол санаандаа дарагдан,

өөрийгөө хэт анхаарч, бусадтай харилцахаас зайлсхийж эхэлбэл хөгжлийн энэ шатны сөрөг тал илэрдэг. Бусадтай тогтвортой, тайван, нөхөрсөг, итгэлтэй харилцааг тогтоож чадахгүй бол ганцаардаж, нийгмээс тасардаг. Ийм хүмүүсийн хувьд дотно харилцаа нь хүмүүст зайлшгүй шаардлага тавьж, аз туршиж, итгэхийг шаарддаг учраас энэ харилцаанаас зайлсхийж байдаг.

1.3.2 Нийгмийн харилцааны онцлог

Хөгжлийн энэ шатанд нийгмийн талаас гарч ирж буй ололтууд нь маш чухал байдаг. Нийгмийн хүрээний ололт, амжилтууд нь хүний ёс суртахууны мэдрэмж бүрэлдэн тогтоход ихээхэн нөлөөтэй юм. Удаан хугацааны үерхэл нөхөрлөл, нийгэмд гүйцэтгэж буй үүргийнхээ үнэ цэнийг ойлгон ухаарсан тэр үеэс хүнд ёс суртахууны мэдрэмж бий болдог. Энэ бүхний ачаар хүн эрхэм нандин зүйлийнхээ төлөө өөрийгөө золиослоход бэлэн байдаг. Энэ насны хүмүүс гол төлөв албан тушаал хөөх, гэрлэх, сурч боловсрох зэрэгт анхаардаг. Судлаач Эриксон залуучуудын нийгмийн онцлогийг өөрийн гэсэн үнэт зүйл, үнэлэмж, баримжааллыг буй болгох оролдлого гэж тайлбарласан бөгөөд энэ оролдлогоороо өөрийнхөө үеийнхний амьдралын утга учир, чиглэлийг тогтоох зорилго, зорилтуудыг олохыг хичээдэг гэжээ (Батдэлгэр, 2021).

1.4 Монгол Улс болон Олон Улс дахь сонгуулийн ирц, насны бүлгээр

Улс орнуудын сонгуулийн ирцийг насны бүлгээр авч үзвэл насны бүлэг дотроо ихээхэн ялгаатай байгааг дараах хэсэгт харж болно. Олон Улсад болсон сүүлийн жилүүдийн томоохон сонгуулиудын ирц дээрх дүн шинжилгээг энэхүү хэсэгт харуулахыг зорив.


1.4.1 Монгол Улсын УИХ болон ИТХ-ын сонгуулийн ирц, насны бүлгээр

Зураг 1.2-т 2024 оны Монгол Улсын ИТХ-ын сонгуульд 2,107,290 үндсэн сонгогчоос 53.1 хувь нь буюу 1,119,881 хүн санал өгсөн байна. Санал өгсөн сонгогчдыг насны бүлгээр авч үзвэл 18-24 насны бүлгийн залуучуудын ирц бусад насны бүлгийн сонгогчидтой харьцуулахад хамгийн бага ирцтэй байна. Үүн дотор 18-19 насны залуу сонгогчдын ирц 35.7 хувь байгаа бол 20-24 насны залуу сонгогчдын ирц 31.2 хувь

байна. Харин 25-аас дээш насны сонгогчдын ирц 50 хувиас илүү байгаа буюу 60-аас дээш насны сонгогчдын ирц 70 хувь давсан байна.

2024 оны 10 сард болсон ИТХ-ын сонгуулийн сонгогчдын ирц 6 сард болсон УИХ-ын сонгуулийн ирц (69.3)-аас зөрүү 16.2 хувиар бага байгаа нь 4 сарын зөрүүтэй сонгууль болоход багагүй зөрүүтэй болж байгаа нь сонгогчид илүү УИХ-ын сонгуульд ирц өндөртэй оролцдог болох нь ажиглагдаж байна.


Зураг 1.2 2024 оны ИТХ-ын сонгуулийн ирц /хувиар/



Эх сурвалж: МУ-ЫН СЕХ

Зураг 1.3-т 2024 оны 6 сард болсон УИХ-ын сонгуульд 2,089,939 үндсэн сонгогчоос 69.2 хувь нь буюу 1,448,300 хүн санал өгсөн байна. Санал өгсөн сонгогчдыг насны бүлгээр авч үзвэл 18-24 насны бүлгийн залуучуудын ирц бусад насны бүлгийн сонгогчидтой харьцуулахад хамгийн бага ирцтэй байна. Үүн дотор 18-19 насны залуу сонгогчдын ирц 61.3 хувь байгаа бол 20-24 насны залуу сонгогчдын ирц 47.5 хувь байна. Харин 25-аас дээш насны сонгогчдын ирц нас ахих тусам өндөр болж байгаа бөгөөд 45-аас дээш наснаас дээш насны сонгогчдын ирц 70-аас дээш хувь буюу ирц өндөр сонгуульд хамрагдаж байна.

Зураг 1.3 2024 оны УИХ-ын сонгуулийн ирц /хувиар/




Эх сурвалж: МУ-ын СЕХ

1.4.2 Бусад улс орны сонгуулийн ирц, насны бүлгээр


Олон улсад залуу сонгогчид дунд болон дундаас дээш насны сонгогчидтой харьцуулахад сонгуулийн ирц мөн адил доогуур байх хандлагатай байгааг харж болно. Бусад улс оронд залуучууд, ахмад настнуудын сонгогчдын ирц ихээхэн ялгаатай байна.

Доорх графикт 5 улсад (Франц, Их Британи, АНУ, Герман, Монгол) болсон үндэсний хэмжээний сонгууль буюу парламентын сонгуулийн мэдээллийг харуулж байна. Монгол Улсын 2020 оны УИХ-ын сонгуулийн нийт ирц 73 хувь байсан бөгөөд насны бүлгээр авч үзвэл 18-25 насны сонгогчдын ирц 62 хувь буюу бусад насны бүлгээс хамгийн бага байсан байна. Харин хамгийн өндөр ирцтэй хэсэг нь 41-55 насны бүлэг 83 хувийн ирцтэй байна. 2022 оны Францын сонгуульд 18-24 насныхны 76 хувь нь санал өгсөн бол хамгийн их ирцтэй насны бүлэг 50-59 насныхны 92 хувь нь санал өгсөн нь 16 хувийн зөрүүтэй байна. Мөн Их Британи болон Герман улсуудад ижил трендтэй байгааг харж болно.


Зураг 1.4 2020 оны Монгол Улсын УИХ-ын сонгуулийн ирц /хувиар/




Зураг 1.5 2019 оны Их Британи Улсын сонгуулийн ирц /хувиар/



Зураг 1.6 2021 оны Герман Улсын сонгуулийн ирц /хувиар/




Зураг 1.7 2022 оны Франц Улсын сонгуулийн ирц /хувиар/




Эх сурвалж: *Our World in Data*

Доорх графикт АНУ-ын 2 жил тутам болдог Конгрессын төлөөлөгчдийн танхим (Конгрессын төлөөлөгчдийн танхим нь 435 гишүүнтэй бөгөөд 2 жил тутамд 2 жилийн хугацаатай сонгогдоно, ингэхдээ хэдэн ч удаа сонгогдож болдог)-ын сонгуулийн ирцийн мэдээллийг харж болно. Үүнд 2016-2022 он хүртэлх 6 жилийн хугацаанд 4 удаагийн сонгуулийн ирцийн мэдээллийг насны бүлгээр харуулахад мөн адил 18-24 насны бүлгийн ирц хамгийн бага байгаа тренд ажиглагдаж байна. Мөн он бүр ирцийн хувь хэлбэлзэж байгааг харж болно.


Зураг 1.8 2022 оны АНУ-ын КТТ-ын сонгуулийн ирц /хувиар/




Зураг 1.9 2020 оны АНУ-ын КТТ-ын сонгуулийн ирц /хувиар/



Зураг 1.10 2018 оны АНУ-ын КТТ-ын сонгуулийн ирц /хувиар/



Зураг 1.11 2016 оны АНУ-ын КТТ-ын сонгуулийн ирц /хувиар/



Эх сурвалж: the Kaiser Family Foundation

Ийнхүү сонгуулийн насны бүлгийн ирцийг Монгол Улс болон бусад улстай харьцуулж авч үзэхэд залуу сонгогчдын ирц бага байгаа тренд ажиглагдаж байна. Монгол Улсад залуучуудын сонгуульд хамрагдалт бусад насны бүлгээс бага байгаа шалтгааныг бид санал асуулгын аргаар судлах зорилготой бөгөөд асуулгаас гарсан үр дүнг дараагийн бүлэгт тайлбарлах болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ШИНЖИЛГЭЭ, ҮР ДҮН

2.1 Судалгааны арга зүй

Уг судалгааны ажил нь асуулгын (survey) судалгааны аргыг ашигласан бөгөөд асуулга нь 3 бүлэг, 2 нээлттэй асуулт, 2 олон сонголттой асуулт, 26 шкал (likert scale) асуултаас бүрдэнэ. Түүврийн хэмжээнд Монгол Улсын хэмжээнд сонгуулийн насны буюу 18-25 насны 117 залуусыг хамруулсан болно. Судалгааг багийн гишүүд цахимаар авсан ба судалгааны үр дүнг SPSS программ ашиглаж дүгнэсэн.

2.1.1 Судалгааны асуулт

Судалгааны анкетын бүтцийн хувьд, ерөнхий мэдээлэл, үндсэн хэсэг буюу хувьсагчдыг үнэлэх, нээлттэй асуулт гэсэн 3 хэсэг бүхий анкетын судалгааг Google Forms платформ ашиглан авсан. Хувьсагчдыг үнэлэхдээ 1-ээс 5 хүртэлх таван онооны Likert Scale-р “Огт санал нийлэхгүй”-с “Бүрэн санал нийлнэ” гэсэн үнэлгээг ашигласан. Мөн хувьсагчдыг үнэлэхдээ чанаргүй түүврээс сэргийлж, хувьсагч бүрд reverse утга бүхий асуулт оруулсан.

Хүчин зүйлс	Хувьсагчид
Зан чанар	<ol style="list-style-type: none">1. Нэр дэвшигч нь өөрийн үзэл бодолдоо үнэнч байх нь чухал.2. Нэр дэвшигч эх оронч үзэлтэй байх эсэх нь надад хамаагүй.*3. Би ард иргэдээ сонсдог нэр дэвшигчийг илүүд үздэг.4. Би аливаа асуудалд сэтгэл хөдлөлөөрөө ханддаг нэр дэвшигчийг сонгоно.*5. Би аливаа зүйлд шударгаар ханддаг нэр дэвшигчийг илүүд үздэг.

Боловсрол

1. Би гадаадын их дээд сургууль төгссөн нэр дэвшигчийг илүүд үздэг.
2. Би мастер болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй нэр дэвшигчийг илүүд үздэг.
3. Нэр дэвшигч ямар мэргэжилтэй байх нь надад чухал биш.*
4. Нэр дэвшигч нь 2 болон түүнээс дээш чиглэлийн мэргэжил эзэмшсэн байх ёстой.
5. Нэр дэвшигчийн гадаад хэлний мэдлэг миний сонголтод нөлөөлөхгүй.*

Манлайллын хэв маяг

1. Нэр дэвшигч нь илтгэх ур чадвартай байх нь чухал.
2. Нэр дэвшигч нь ард иргэдийнхээ хүсэл сонирхолд нийцсэн шийдвэр гаргадаг байх хэрэгтэй.
3. Нэр дэвшигч нь харизматик (бусдад нөлөөлөх чадвартай) байх эсэх нь надад чухал биш.*
4. Би шинийг санаачлагч, түүнийгээ хэрэгжүүлж чаддаг нэр дэвшигчийг сонгоно.
5. Надад нэр дэвшигч нь хийсэн үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээх чадвартай байх эсэх нь чухал биш.*

Хувийн замнал

1. Би эгэл жирийн гэр бүлээс гаралтай нэр дэвшигчид итгэдэг.
 2. Нэр дэвшигчийн гэр бүлийн байдал нь тогтвортой байх эсэх нь надад чухал биш.*
 3. Цахим орчинд соёлтой улс төрчийг би илүүд үзнэ.
 4. Би удам дамжсан улс төрч, нэр дэвшигчийг илүүд үзнэ.*
 5. Нэр дэвшигч нь ямар нэгэн гэмт хэрэг, цуурхалд өртөөгүй байх нь миний сонголтод нөлөөлнө.
 6. Нэр дэвшигчийн гэр бүлийн хүн нь аль ч улсын харьяалалтай байх нь надад хамаагүй.
-

Туршлага


1. Би урьд өмнө улс төрд нэр дэвшин, ажиллаж байсан нэр дэвшигчийг сонгохыг илүүд үздэг.
2. Нэр дэвшигч нь өөрийн эзэмшсэн мэргэжлээрээ тогтвортой ажиллаж байсан эсэх нь миний сонгох нэг шалгуур болно.
3. Мэдлэг, ур чадвар өндөртэй боловч залуу нэр дэвшигчийг би сонгохгүй.*
4. Би олон төрлийн ажил хөдөлмөр эрхэлж байсан туршлагатай нэр дэвшигчийг илүүд үздэг.
5. Урлаг, соёл, спортын амжилтаараа олонд танигдсан нэр дэвшигчийг би илүүд үзнэ.*

*Тэмдэглэгээтэй судалгааны асуулгууд нь урвуу буюу reverse утгатай бөгөөд шинжилгээ хийхэд урвуулан reverse хийсэн болно.


2.2 Шинжилгээ, үр дүн

2.2.1 Судалгаанд оролцогчдын мэдээлэл

Зураг 2.1 Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа /хувиар/




Зураг 2.2 Судалгаанд оролцогчдын нас /хувиар/




Судалгаанд оролцогчид хүйсийн хувьд харьцангуй тэнцвэртэй тооны оролцогчид байгаа бөгөөд эрэгтэй 51.3 хувь (60), эмэгтэй 47.9 хувь (56) байна. Харин насны хувьд, оролцогчдын ихэнх хувийг 21-23 (53.8 хувь) насны залуучууд эзэлж байна.

Зураг 2.3 Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин /хувиар/




Зураг 2.4 Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлт




Бүрэн дунд (41.9 хувь) болон дээд (52.1 хувь) боловсролтой оюутан (48.7 хувь), бизнесийн байгууллагад ажилладаг залуус (19.7 хувь) оролцогчдын дийлэнх хувийг бүрдүүлж байна.

Зураг 2.5 Судалгаанд оролцогчдын харьяалал /хувиар/




Судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь буюу 53.8 хувь нь Улаанбаатар хотын харьяалалтай бол үлдсэн 46.2 хувь нь орон нутгийн харьяалалтай байна.

Зураг 2.6 Судалгаанд оролцогчдын гэрлэлтийн байдал /хувиар/



Зураг 2.7 Судалгаанд оролцогчдын сарын орлого /тоогоор/



Оролцогчдын дийлэнх хувь ганц бие бөгөөд сарын орлогынх нь хувьд 39.3 хувь нь 660'000 хүртэлх төгрөгийн орлоготой байна.

Хүснэгт 2.1 Оролцогчдын ерөнхий мэдээлэл

Хүн ам зүйн мэдээлэл	N	%
Хүйс		
Эрэгтэй	60	51.3%
Эмэгтэй	56	47.9%
Бусад	1	0.9%
Нас		
18	11	9.4%
19	16	13.7%
20	10	8.5%
21	19	16.2%
22	24	20.5%
23	20	17.1%
24	8	6.8%
25	9	7.7%

Харьяалал		
Улаанбаатар хот	63	53.8%
Орон нутаг	54	46.2%
Боловсролын түвшин		
Бүрэн бус дунд	-	-
Бүрэн дунд	49	41.9%
Техник мэргэжлийн боловсрол	3	2.6%
Дээд /Бакалавр/	61	52.1%
Магистр	4	3.4%
Доктор	-	-
Бусад	-	-
Гэрлэлтийн байдал		
Ганц бие	103	88%
Гэрлэсэн	8	6.8%
Хамтран амьдардаг	6	5.1%
Хөдөлмөр эрхлэлтийн байдал		
Сурагч	2	1.7%
Оюутан	57	48.7%
Төрийн байгууллагад ажилладаг	23	19.7%
Бизнесийн байгууллагад ажилладаг	8	6.8%
Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	12	10.3%
Бусад	15	12.8%

Сарын орлого		
0-660'000₮ хүртэлх	46	39.3%
660,001₮-1,000,000₮	7	6%
1,000,001₮-1,500,000₮	13	11.1%
1,500,001₮-2,500,000₮	29	24.8%
2,500,001₮-3,500,000₮	12	10.3%
3,500,001₮ ба түүнээс дээш	10	8.5%

2.2.2 Статистик үр дүн

2.2.2.1 Нэр дэвшигчийн ерөнхий мэдээлэл

Хүснэгт 2.2 Нэр дэвшигчийн насны бүлэг

	Насны бүлэг	N	Percent
Хэдэн настай нэр дэвшигчийг сонгох хүсэлтэй байна вэ?	25-29	25	11.40%
	30-34	56	25.60%
	35-39	59	26.90%
	40-44	42	19.20%
	45-49	17	7.80%
	50-54	12	5.50%
	55-59	2	0.90%
	60-64	1	0.50%
	65-69	2	0.90%
	70-74	2	0.90%
	75-79	1	0.50%
Total		219	100.00%

Судалгаанд оролцогчдын ихэнх хувь нь давхардсан тоогоор 30-44 насны нэр дэвшигчийг сонгох хүсэлтэй байна.

Хүснэгт 2.3 Нэр дэвшигчийн хүйс

Нэр дэвшигчийн хүйс		
	Frequency	Percent
Эмэгтэй	9	7.7
Эрэгтэй	35	29.9
Аль нь ч хамаагүй	73	62.4
Total	117	100

Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь буюу 62.4 хувь нь аль ч хамаагүй буюу тэдний сонголтод хүйс тийм ч хамааралтай биш хэмээн хариулжээ. Харин түүний дараа оролцогчдын гуравны нэг нь эрэгтэй хүйсийн нэр дэвшигчийг илүүд үзэхээ илэрхийлжээ.

Хүснэгт 2.4 Нэр дэвшигчийн мэргэжил

	Мэргэжил	N	Percent
Таны сонгох нэр дэвшигч ямар мэргэжилтэй байх нь дээр гэж бодож байна вэ?	Улс төр судлаач	72	15.86%
	Эрүүл мэндийн салбарын мэргэжилтэн	33	7.27%
	Нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухааны мэргэжилтэн	50	11%
